ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2025/102/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дундговь аймаг<br>2025 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох<br>Утас: 70592439<br>Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ<br>Утас: 70592225<br>Цахим хаяг: oyun-erdenet@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Д.Ихбаяр<br>Утас: 70593113<br>Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn<br><br>Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК Утас: 77233030<br>Цахим хаяг: info@cptaaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.28 № 61

танай ________ -ны № ________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГУРВАНСАЙХАН СУМЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Э.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 341,542.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн, утасгүй интернэтийн орчин бүрдүүлэхээр Мобинет ХХК-аас 39,522.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж зээлээр авч, 25,000.0 мянган төгрөгийн өр үүссэн. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4825020209

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 1 хөтөлбөр, 15 арга хэмжээний гүйцэтгэл 85.9 хувьтай, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 8 зорилт, 21 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласнаар Боловсролын газраас гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 81.0 хувиар үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **136,095,048.98** | **366,609,058.06** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 74,085,292.70 | 284,005,703.05 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 74,085,292.70 | 284,005,703.05 |
| **3121** | **Төгрөг** | 74,085,292.70 | 284,005,703.05 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 73,862,544.32 | 283,782,954.67 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 222,748.38 | 222,748.38 |
| **33** | **АВЛАГА** | 0.50 | 98,674.63 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.50 | 98,674.63 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 62,009,755.78 | 82,504,680.38 |
| **351** | **Түүхий эд материал** | 13,319,200.00 | 13,379,150.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 13,296,800.00 | 13,296,800.00 |
| 35130 | Эм боох материал | 22,400.00 | 82,350.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 48,690,555.78 | 69,125,530.38 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 351,100.00 | 503,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 44,349,418.18 | 65,636,984.18 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 20,000.00 | 872,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 80,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 987,200.00 | 928,200.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,982,837.60 | 1,104,746.20 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,709,283,871.39** | **3,666,039,849.14** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,709,283,871.39 | 3,666,039,849.14 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,633,328,184.15 | 3,591,201,403.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,992,880,173.82 | 3,992,880,173.82 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (655,823,268.78) | (765,589,678.66) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 25,000,000.00 | 8,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (24,374,999.61) | - |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 287,273,691.20 | 353,533,504.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (61,302,286.18) | (89,274,141.09) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 100,212,764.50 | 123,018,166.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (45,945,796.42) | (47,569,029.53) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 810,700.00 | 810,700.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (471,720.20) | (531,266.84) |
| 39217 | Ном | 15,068,925.82 | 15,922,975.82 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 75,955,687.24 | 74,838,445.32 |
| 39301 | Програм хангамж | 7,413,420.00 | 7,413,420.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,457,732.76) | (2,574,974.68) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 70,000,000.00 | 70,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,845,378,920.37** | **4,032,648,907.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **143,547,275.50** | **133,267,750.03** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 143,547,275.50 | 133,267,750.03 |
| **413** | **Өглөг** | 143,547,275.50 | 133,267,750.03 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 4,755,979.49 |

| | | | |
|---|---|---|---|
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 58,326,275.40 | 37,993,251.44 |
| **4136** | **Бусад өглөг** | 85,221,000.10 | 90,518,519.10 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 85,221,000.00 | 90,518,519.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.10 | 0.10 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,701,831,644.87** | **3,899,381,157.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,701,831,644.87 | 3,899,381,157.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 473,662,503.98 | 473,662,503.98 |
| 51101 | Өмч: - төрийн | 473,662,503.98 | 473,662,503.98 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,968,278,463.76 | 3,165,827,976.06 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,992,302,362.05 | 2,968,278,463.76 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 975,976,101.71 | 197,549,512.30 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 259,890,677.13 | 259,890,677.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,845,378,920.37** | **4,032,648,907.20** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,236,421,197.28** | **1,928,225,018.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,054,720,597.28** | **114,039,118.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,054,720,597.28 | 114,039,118.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,975,731.20 | 16,529,017.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,975,731.20 | 16,529,017.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,028,969,259.00 | 96,494,401.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 13,775,607.08 | 1,015,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,181,700,600.00** | **1,814,185,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,037,876,700.00 | 1,580,641,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,037,876,700.00 | 1,580,641,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 143,823,900.00 | 233,544,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 143,823,900.00 | 233,544,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,258,074,147.52** | **1,738,338,615.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,258,074,147.52** | **1,738,338,615.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,221,122,732.14 | 1,738,038,484.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 722,319,722.00 | 1,063,665,299.62 |
| 210101 | Үндсэн цалин | 526,668,049.50 | 678,428,387.35 |
| 210102 | Нэмэгдэл | 163,759,198.50 | 342,775,149.27 |
| 210104 | Урамшуулал | 31,892,474.00 | 42,461,763.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 90,347,842.20 | 129,913,249.62 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,689,462.13 | 88,702,273.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,272,463.94 | 10,500,311.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,970,854.43 | 5,659,185.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,387,081.26 | 5,010,296.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,027,980.44 | 20,041,182.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 183,003,364.52 | 208,725,154.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,429,002.02 | 3,787,131.71 |
| 210302 | Түлш, халаалт | 169,143,917.30 | 194,040,490.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,430,445.20 | 10,897,532.84 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,734,822.15 | 23,979,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,965,030.00 | 8,336,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,154,600.00 | 6,208,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,581,290.00 | 8,163,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,033,902.15 | 1,271,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 66,831,523.20 | 107,300,564.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 434,190.00 | 251,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 66,397,333.20 | 107,049,364.90 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,226,600.00 | 4,811,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,226,600.00 | 4,811,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,496,400.00 | 11,767,965.27 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 894,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,496,400.00 | 10,873,965.27 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 124,162,458.07 | 187,875,200.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,188,211.20 | 16,620,089.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 109,974,246.87 | 171,255,111.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,951,415.38 | 300,131.49 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,634,917.40 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,405,032.40 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,229,885.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 316,497.98 | 300,131.49 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 316,497.98 | 300,131.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **978,347,049.76** | **189,886,402.35** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,370,948.05 | 1,654,112.05 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,370,948.05 | 1,654,112.05 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (2,370,948.05) | (1,654,112.05) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **975,976,101.71** | **188,232,290.30** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,193,676,331.20** | **1,830,714,917.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,975,731.20** | **16,529,017.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 11,975,731.20 | 16,529,017.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 11,975,731.20 | 16,529,017.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,975,731.20 | 16,529,017.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,181,700,600.00** | **1,814,185,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,037,876,700.00 | 1,580,641,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,037,876,700.00 | 1,580,641,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 143,823,900.00 | 233,544,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 143,823,900.00 | 233,544,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,096,628,333.80** | **1,613,134,506.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,096,628,333.80** | **1,613,134,506.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,060,017,883.82** | **1,583,692,156.66** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 722,319,722.40 | 1,059,007,994.26 |
| 210101 | Үндсэн цалин | 526,668,049.90 | 691,216,487.23 |
| 210102 | Нэмэгдэл | 163,759,198.50 | 313,180,756.28 |
| 210104 | Урамшуулал | 31,892,474.00 | 54,610,750.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 90,347,842.20 | 129,913,249.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,689,462.13 | 88,702,273.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,272,463.94 | 10,500,311.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,970,854.43 | 5,659,185.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,387,081.26 | 5,010,296.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,027,980.44 | 20,041,182.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 140,013,602.02 | 228,737,468.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,429,002.02 | 3,787,131.71 |
| 210302 | Түлш, халаалт | 126,883,600.00 | 215,999,380.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,701,000.00 | 8,950,956.80 |
| **2105** | **Нормативт зардал** | 65,689,726.00 | 70,733,865.00 |
| 210502 | Хоол, хүнс | 65,689,726.00 | 70,733,865.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,493,800.00 | 4,507,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,493,800.00 | 4,507,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,496,400.00 | 13,307,965.27 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 894,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,496,400.00 | 12,413,965.27 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,656,791.20 | 77,484,314.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,176,791.20 | 67,429,614.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,480,000.00 | 10,054,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **36,610,449.98** | **29,442,349.99** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 316,497.98 | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 316,497.98 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,293,952.00 | 29,142,218.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,064,067.00 | 29,142,218.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,229,885.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 300,131.49 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 300,131.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **97,047,997.40** | **217,580,410.35** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **28,553,750.00** | **7,660,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **28,553,750.00** | **7,660,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 28,553,750.00 | 7,660,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 28,553,750.00 | 7,660,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(28,553,750.00)** | **(7,660,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 68,494,247.40 | 209,920,410.35 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5,591,045.30 | 74,085,292.70 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 74,085,292.70 | 284,005,703.05 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** /төгрөгөөр/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 473,662,503.98 | 259,890,677.13 | 1,992,302,362.05 | 2,725,855,543.16 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 473,662,503.98 | 259,890,677.13 | 1,992,302,362.05 | 2,725,855,543.16 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 975,976,101.71 | 975,976,101.71 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 473,662,503.98 | 259,890,677.13 | 2,968,278,463.75 | 3,701,831,644.86 |
| D01 | **20724 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 473,662,503.98 | 259,890,677.13 | 2,968,278,463.75 | 3,701,831,644.86 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 473,662,503.98 | 259,890,677.13 | 2,968,278,463.75 | 3,701,831,644.86 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 197,549,512.30 | 197,549,512.30 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 473,662,503.98 | 259,890,677.13 | 3,165,827,976.05 | 3,899,381,157.16 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** /төгрөгөөр/

| ЭЗА | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,885,945,500.00** | **1,620,494,375.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,885,945,500.00** | **1,620,494,375.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,853,881,800.00** | **1,591,352,156.66** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,244,464,400.00** | **1,059,007,994.26** |
| 210101 | Үндсэн цалин | 795,141,800.00 | 691,216,487.23 |
| 210102 | Нэмэгдэл | 423,134,000.00 | 313,180,756.28 |
| 210104 | Урамшуулал | 26,188,600.00 | 54,610,750.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 155,558,100.00 | 129,913,249.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 105,779,500.00 | 88,702,273.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,444,700.00 | 10,500,311.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,222,300.00 | 5,659,185.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,222,300.00 | 5,010,296.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,889,300.00 | 20,041,182.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 228,862,900.00 | 228,737,468.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,907,300.00 | 3,787,131.71 |
| 210302 | Түлш, халаалт | 216,004,600.00 | 215,999,380.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,951,000.00 | 8,950,956.80 |
| **2105** | **Нормативт зардал** | 102,443,900.00 | 70,733,865.00 |
| 210502 | Хоол, хүнс | 102,443,900.00 | 70,733,865.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,682,000.00 | 4,507,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,682,000.00 | 4,507,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 22,206,300.00 | 13,307,965.27 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,461,000.00 | 894,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 20,745,300.00 | 12,413,965.27 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 95,664,200.00 | 85,144,314.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,574,700.00 | 75,089,614.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,089,500.00 | 10,054,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 32,063,700.00 | 29,142,218.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 32,063,700.00 | 29,142,218.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 32,063,700.00 | 29,142,218.50 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,885,945,500.00** | **1,830,414,785.51** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,580,641,000.00** | **1,580,641,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,580,641,000.00 | 1,580,641,000.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **233,544,900.00** | **233,244,768.51** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 233,544,900.00 | 233,244,768.51 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **71,759,600.00** | **16,529,017.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 16,529,017.00 | 16,529,017.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 55,230,583.00 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **73,862,544.32** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **283,782,954.67** |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 15,203.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 9,935.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 429.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,839.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаарлага хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт 9,935.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1.Ажилтны цалингаас 98.7 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрийн дагуу хийх суутгалыг суутгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-т /Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална/, 5.1.4-т /*үнэн зөв байх*/ заасныг зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.Нийгмийн даатгалын сангаас санхүүжих хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтны тэтгэмж 116.9 мянган төгрөгийн санхүүжилтийг орлогоор бүртгэж тайлагнасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйл: 23.3./*Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ/* заасныг зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 6,240.0 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнаагүй. *Энэ нь* 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т */үнэн зөв байх/* заасныг зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.ХХОАТ, НДШ-ийн 2,059.6 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д /*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/ заасныг зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1,420.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгийн зардалд тусгаагүй. Энэ нь 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т /*үнэн зөв байх/* заасныг зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 5,268.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 429.1 мянган төгрөгийн акт тогтоож, 4,839.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Ажилтанд **429.1 мянган төгрө**гийн цалин хөлсийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжтэй давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/,* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.-т /*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*/, НББТХ-ийн 13.1-т /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/* заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

3.2.1 Ажлын байрны тодорхойлолтод заагдсан албан үүргээ гүйцэтгэсэн ердийн цагаар ажилладаг албан хаагчид хууль эрх зүйн үндэслэлгүйгээр 2,326.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.-д /*Ажилтныг ажил олгогчийн санаачилгаар ердийн ажлын өдрийн үргэлжлэл, ээлжийн ажлын цаг, долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэл болон ажлын цагийг нэгтгэн бодох ердийн ажлын цагийн нийлбэрээс хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно./* , 91.2.4.-т /*урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай гүйцэтгэхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадаас урьдчилан сэргийлэх, эсхүл учирсан саадыг арилгахад чиглэгдсэн хойшлуулшгүй ажил гүйцэтгэх./* заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна**.**

3.2.2 Нягтлан бодогч, нярвын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон болович ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 2,513.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна**.**

3.2.3 Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 207.6 сая төгрөгийн 6, зарлагын 172.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 22.9 сая төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй. мэдээлсэн байдлын хэрэгжилт 88.3 хувьтай, хугацаа хоцролтын хувь 93 хувьтай. Энэ нь Шилэн

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /*Шилэн дансны зарчим/* 4.1.1-д /*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;*/, /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;* /, 6 дугаар зүйлийн 6.4-т /Энэ хуулийн *3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*:/, 6.4.8-д /*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;*/, 7.2 -т /*Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.*/ заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:** **/мянган төгрөг/**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажилтны цалингаас шүүхийн шийдвэрийн дагуу хийх суутгалыг аваагүй. | 1 | 98.7 | 1 | 98.7 | | | 1 | 98.7 | | | | |
| Нийгмийн даатгалын сангаас авсан хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтны тэтгэмжийн санхүүжилтийг орлогоор бүртгэж тайлагнасан. | 1 | 116.9 | | | 1 | 116.9 | 1 | 116.9 | | | | |
| Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнаагүй. | 1 | 6,240.0 | | | 1 | 6,240.0 | 1 | 6,240.0 | | | | |
| ХХОАТ, НДШ-ийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй. | 1 | **2,059.6** | **1** | **2,059.6** | | | **1** | **2,059.6** | | | | |
| Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгийг хөрөнгийн зардалд тусгаагүй. | 1 | **1,420.0** | | | **1** | **1,420.0** | **1** | **1,420.0** | | | | |
| Дүн | **5** | **9,935.2** | **2** | **2,158.3** | **3** | **7,776.9** | **5** | **9,935.2** | | **-** | **-** | **-** |

**2.Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** **/мянган төгрөг/**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажилтанд цалин хөлсийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжтэй давхардуулан олгосон. | 1 | 429.1 | 1 | 429.1 | | | | | | | | |
| Ажлын байрны тодорхойлолтод заагдсан албан үүргээ гүйцэтгэсэн ердийн цагаар ажилладаг албан | 1 | 2,326.6 | | | 1 | 2,326.6 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хаагчид хууль эрх зүйн үндэслэлгүйгээр илүү цагийн хөлс тооцож олгосон. | | | | | | | | | | | | |
| Нягтлан бодогч, нярвын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон. | 1 | 2,513.0 | | | 1 | 2,513.0 | | | | | | |
| **Дүн** | **3** | **5,268.7** | **1** | **429.1** | **2** | **4,839.6** | | | - | - | - | - |

### 3.Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 207.6 сая төгрөгийн 6, зарлагын 172.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 22.9 сая төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй. мэдээлсэн байдлын хэрэгжилт 88.3 хувьтай, хугацаа хоцролтын хувь 93 хувьтай. | 1 | - | | | 1 | - | | | | |
| Дүн | 1 | - | | | 1 | - | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |